

2024.04.27

№24/01

Улаанбаатар хот

**АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

*Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай*

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл 62.1.9 дэх хэсэг, "Ард Санхүүгийн Нэгдэл"
ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 4 сарын 27-ны өдрийн хурлын тэмдэглэл
болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны үйл
ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2024.04.27

№24/02

Улаанбаатар хот

**АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл 62.1.13 дахь хэсэг, "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 4 сарын 27-ны өдрийн хурлын тэмдэглэл болон Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсвийг энэхүү тогтоолын Хавсралт 1-ийн дагуу баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, Нэр дэвшүүлэх болон Цалин, Урамшууллын хороонд, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороонд тус тус даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

**“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны төсөв**

Утга	Төсөв 2023 (сая тогрог)	Гүйцэтгэл 2023 (сая тогрог)	Гүйцэтгэл (хувиар)	Төсөв 2024 (сая тогрог)
ГУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал	424	451.5	106.50%	420.8
Төмилөлтын зардал	10	22	220.00%	100
Нийт	434	473.5	109.10%	520.8

2024.04.27

№24/03

Улаанбаатар хот

**АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл 62.1.1, Хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 сарын 27-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг энэхүү тогтоолын Хавсралт 1-ийн дагуу баталсугай.
2. Дүрмийн шинэчилсэн найруулгыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх, бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Золбоод үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ